



Энэхүү хичээлийн арга зүйн санаа нь ээлжит хичээлийг төлөвлөх, заах багшийн арга зүйг сайжруулах, сурагчдын сурлагын амжилтыг ахиулах, сургууль, багш нар сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд чиглэнэ.

Үнэлгээний даалгавар, сурагчдын гүйцэтгэл

Даалгаврын зорилго: Нийгмийн ухааны шинжлэн судлах арга барилын эхний алхам болох таамаглал дэвшүүлэх алхмыг ялгах

Хүснэгт 4. Сурагчдын гүйцэтгэл

Хариултын дугаар	Хариулт	Гүйцэтгэл %	Зөв хариулт
1	А	32.2	
2	Б	23.6	
3	В	10.4	+
4	Г	29.2	
5	Огт хариулаагүй	2.6	
6	Хүчингүй хариулт	1.9	

Шинжилгээний үр дүн, асуудал: Сорилд оролцсон сурагчдын 10.4 хувь нь нийгмийн ухааны хичээлд шинжлэн судлах арга барилын эхний алхам болох таамаглалыг зөв нэрлэсэн. Таамаглал ба мэдээллийн ялгааг таних чадвар сул байна. Жишээ нь, хүн амын тооллогын дүнгээр Монгол улсад хүний дундаж наслалт 67 байна гэсэн хувилбарыг сурагчдын 32.2 хувь нь сонгосон байна. Цөөнгүй сурагч таамаглал гэж хичээл дээр судлаагүй гэж бичсэн байна. Уг арга барилыг нийгмийн ухааны хичээлд төдийлэн хэрэглэхгүй байгаа нь ажиглагдаж байна.

ХИЧЭЭЛИЙН АРГА ЗҮЙН САНААНЫ ЖИШЭЭ

Суралцахуйн зорилт: 8.1б. Орон нутагт тулгамдаж буй асуудлуудыг судлах, эдгээр нь хүмүүсийн байр суурь, үүрэг, соёлын ялгаанаас хэрхэн хамаарч байгааг тодорхойлох

Хичээлийн үе шат	Арга зүйн санаа
1. Сэдэлжүүлэлт (түүхийн асуулт асуух)	 <p>1. Зургийг анхааралтай ажиглана уу. Асуух үгсийг ашиглан Хар хорум дахь мөнгөн модны талаар түүхийн асуулт гаргана. Асуух үгс: Хаана?, Хэзээ?, Юу?, Яагаад?, Хэрхэн?, Ямар үр дүн, сургамжид хүрэв?</p> <p>Сурагчийн зохиож болох асуулт: -Зурагт Монголын түүх, соёлын ямар дурсгалыг харуулсан бэ? -Зураг дахь түүх, соёлын дурсгалыг нэрлэнэ үү? г.м.</p> <p>Асуултуудын хариултыг хосоор ярилцаж, тус тусын хариултыг анги нийтэд мэдээлнэ. Ярилцлагын дүнд сурагчдын гаргаж болох хариулт: Монголын түүх, соёлын дурсгал, Хар хорум хот, Мөнгөн мод г.м.</p> <p>Багшийн дэмжлэгтэйгээр сурагчдын дэвшүүлэх асуултууд:</p> <ul style="list-style-type: none">• Их монгол улсын үеийн түүх, соёлын ямар, гол дурсгалууд байдаг бэ? Нотлох баримт, эх сурвалж юу вэ?• Мөнгөн модыг ямар зорилгоор, хэдийд, хаанахын, ямар уран бүтээлчид, хэрхэн, яаж бүтээсэн бэ?• Мөнгөн модны бүтэц, хийц, утга бэлгэдлийг хэрхэн тайлбарлаж болох вэ?• Мөнгөн модны үнэ цэнэ, бахархах зүйл юу вэ?• Эдгээр асуултын хүрээнд гүйцэтгэх үйл ажиллагаагаа төлөвлөн хэрэгжүүлнэ.

<p>2. Үйлийг төлөвлөх</p>	<p>2. Их монгол улсын үеийн түүх, соёлын гол дурсгалуудын талаар холбогдох баримт, эх сурвалжуудыг шинжилж, гүйцэтгэх даалгаварт ажиллана.</p> <p>Даалгавар1. Их Монгол улсын түүх, соёлын гол дурсгалуудыг дараах ажлын хуудсанд жагсаан бичиж, эдгээрээс өнөөг хүртэл өвлөгдөж ирсэнийг зааврын дагуу ялган тэмдэглээрэй.</p> <table border="1" data-bbox="472 304 1406 450"> <thead> <tr> <th data-bbox="472 304 539 405">№</th> <th data-bbox="539 304 959 405">Их Монгол улсын үеийн түүх, соёлын гол дурсгалууд</th> <th data-bbox="959 304 1406 405">Бидэнд өвлөгдөж ирсэн + тэмдэг, өвлөгдөж ирээгүй - тэмдэг тавиарай.</th> </tr> </thead> <tbody> <tr> <td data-bbox="472 405 539 450"></td> <td data-bbox="539 405 959 450"></td> <td data-bbox="959 405 1406 450">+</td> </tr> </tbody> </table>	№	Их Монгол улсын үеийн түүх, соёлын гол дурсгалууд	Бидэнд өвлөгдөж ирсэн + тэмдэг, өвлөгдөж ирээгүй - тэмдэг тавиарай.			+
№	Их Монгол улсын үеийн түүх, соёлын гол дурсгалууд	Бидэнд өвлөгдөж ирсэн + тэмдэг, өвлөгдөж ирээгүй - тэмдэг тавиарай.					
		+					
<p>3. Баримт, мэдээллийг задлан шинжлэх, нэгтгэх, нотлох</p>	<p>3. Холбогдох баримт, мэдээллийг задлан шинжлэх, нэгтгэх, нотлоход доорх 4 өөр эх сурвалжид сурагч бүр харьцуулалт хийнэ.</p> <p>А. Монгол улсын нутаг дэвсгэрт Хүннүгийн 9, Түрэг, Уйгурын үеийн 5, Киданы үеийн 13, XIII-XIV зууны үеийн 23 хот, сууринг нэрээр нь жагсаан тус бүрийн байршлын талаар тодорхой тайлбарласан. Эх сурвалж: Д.Майдар “Монголын архитектур ба хот байгуулалт” Б. Чингис хаан 1220 онд Хархорум хотыг их Монгол Улсын нийслэл болгох зарлиг буулгаж, Мөнх хааны үед цэцэглэн хөгжжээ.Тухайн үеийн шилдэг уран дархчуудын бүтээсэн нэгэн томоохон бүтээл бол Түмэн Амгалант ордон дотор байрлаж, уран гоё хийцээрээ олон түмэнд шагшигдаж байсан Мөнгөн мод юм. Түүнийг бүтээх ажлыг Мөнх хаан Францын нийслэл Парис хотын алдарт уран дархан Вильгельм Бушьед хааны сангаас санхүүжилт хиилгэн 50 туслах дархан өгч бүтээлгэжээ. Вильгельм Бушье түүнийг 1254 онд хийж дуусгаад, Түмэн Амгалант их ордны дотор талд, хааны сэнтийн өмнөх талбайд байрлуулжээ. Мөнгөн модны ёроолд тус бүрээс нь айраг олгойдон гарах цоргон амтай дөрвөн арслан байрлуулжээ. Модны дотуур оройд нь хүртэл дөрвөн босоо хоолой татаж, тэдгээрийн амсрыг доош унжуулан, тус бүрийн амсрыг алтан шармал могойн ам маягтай үйлдэж сүүлээр нь мөнгөн модыг ороолгон урлажээ. Эдгээр хоолойн нэгээс дарс, нөгөөгөөс дан айраг, гурав дахиас балын ундаа, дөрөв дэхээс будааны шар айраг гоождог байв. Модны ёроол хавьд амттан ундааг юүлэх тусгай мөнгөн савнуудыг хоолой бүрийн дор тосон байрлуулжээ. Мөнгөн модны орой дээр бүрээ барьсан Ангель хэмээх тэнгэрийн элчийн дүрийг Вильгельм дархан урлан босгож модны доорхи газарт хүн далд орохуйц зоорь бэлдэн модны голоор Ангелийг хүртэл бас нэг цорго үйлджээ. Модны мөчир, навч, жимс бүгдийг дан мөнгөөр урлажээ.</p> <p>В. Монголын их хаад аливаа шашныг ялгаварлан үздэггүй шашин шүтэх эрх чөлөөг эрхэмлэн дээдэлдэг байсан. Хар хорум хотод дэлхийн 3 том шашин болох Будда, Христос, Лалын болон бөө мөргөлийн ёсны төлөөлөгчид тус тусын сүм хийдийг байгуулж, шашин номын үйл ажиллагаа явуулж байжээ. Г. Монголын эртний нийслэл Хархорум хотын туурь Монгол улсын Өвөрхангай аймгийн Хархорин сумын нутагт оршдог. Хархорум хотын туурийг 1948-1949 онд С.В.Кисилев, Х.Пэрлээ нарын, 1978-1985 онд Н.Сэр-Оджав, Д.Цэвээндорж, Д.Баяр нарын, 1995-1997 онд ЮНЕСКО-гийн ивээл дор Монгол, Японы судлаач эрдэмтэд, 2000 оноос Монгол, Германы эрдэмтэд судлан шинжилсэн. Судалгаа шинжилгээний ажил, археологийн малтлагын үр дүн, олдсон олдвор хэрэглэгдэхүүнүүд нь Хархорум хотын хөгжил, төлөвлөлт, барилга архитектурын хөгжлийн төвшин, цар хүрээ, онцлогийг тал бүрээс нь нээн харуулж, Хархорум нь тухайн үедээ өрнө, дорнын олон улс орныг холбосон Монголын эзэнт гүрний Нийслэл хот байсныг давхар нотлоод байна.</p> <p style="text-align: right;">https://mongoltoli.mn/history/h/685</p>						
<p>4. Үр дүнгийн танилцуулга</p>	<p>1. Дээр дурдсан эх сурвалж А болон Б-г харьцуулан шинжилж, дараах асуултуудад хариулна уу.</p> <ul style="list-style-type: none"> - Их монгол улсын үед хот суурин байсан уу? байсан бол ямар нэртэй байсан бэ? Нотолж болох баримт, эх сурвалж юу вэ? - Мөнгөн модыг ямар зорилгоор, хэдийд, хаанахын, ямар уран бүтээлч, хэрхэн, яаж бүтээсэн бэ? <p>2. Эх сурвалж Б болон В-г харьцуулан шинжилж, дараах асуултад хариулна уу.</p> <ul style="list-style-type: none"> - Ангель хэмээх тэнгэрийн элчийн дүрийг яагаад дүрсэлсэн бэ? Мөнгөн модны утга бэлгэдэл юу вэ? <p>3. Эх сурвалж А,Б,В,Г-г харьцуулан шинжлээд дараах асуултад хариулна уу</p> <ul style="list-style-type: none"> - Мөнгөн модыг бүтээсэн шалтгаан юу вэ? Бахархах зүйл, үнэ цэнэ нь юу вэ? 						

2. Үйлийг төлөвлөх

2. Их монгол улсын үеийн түүх, соёлын гол дурсгалуудын талаар холбогдох баримт, эх сурвалжуудыг шинжилж, гүйцэтгэх даалгаварт ажиллана.

Даалгавар1. Их Монгол улсын түүх, соёлын гол дурсгалуудыг дараах ажлын хуудсанд жагсаан бичиж, эдгээрээс өнөөг хүртэл өвлөгдөж ирсэнийг зааврын дагуу ялган тэмдэглээрэй.

№	Их Монгол улсын үеийн түүх, соёлын гол дурсгалууд	Бидэнд өвлөгдөж ирсэн + тэмдэг, өвлөгдөж ирээгүй - тэмдэг тавиарай.
		+

3. Баримт, мэдээллийг задлан шинжлэх, нэгтгэх, нотлох

3. Холбогдох баримт, мэдээллийг задлан шинжлэх, нэгтгэх, нотлоход доорх 4 өөр эх сурвалжид сурагч бүр харьцуулалт хийнэ.

А. Монгол улсын нутаг дэвсгэрт Хүннүгийн 9, Түрэг, Уйгурын үеийн 5, Киданы үеийн 13, XIII-XIV зууны үеийн 23 хот, сууринг нэрээр нь жагсаан тус бүрийн байршлын талаар тодорхой тайлбарласан. Эх сурвалж: Д.Майдар “Монголын архитектур ба хот байгуулалт” Б. Чингис хаан 1220 онд Хархорум хотыг их Монгол Улсын нийслэл болгох зарлиг буулгаж, Мөнх хааны үед цэцэглэн хөгжжээ.Тухайн үеийн шилдэг уран дархчуудын бүтээсэн нэгэн томоохон бүтээл бол Түмэн Амгалант ордон дотор байрлаж, уран гоё хийцээрээ олон түмэнд шагшигдаж байсан Мөнгөн мод юм. Түүнийг бүтээх ажлыг Мөнх хаан Францын нийслэл Парис хотын алдарт уран дархан Вильгельм Бушьед хааны сангаас санхүүжилт хиилгэн 50 туслах дархан өгч бүтээлгэжээ. Вильгельм Бушье түүнийг 1254 онд хийж дуусгаад, Түмэн Амгалант их ордны дотор талд, хааны сэнтийн өмнөх талбайд байрлуулжээ. Мөнгөн модны ёроолд тус бүрээс нь айраг олгойдон гарах цоргон амтай дөрвөн арслан байрлуулжээ. Модны дотуур оройд нь хүртэл дөрвөн босоо хоолой татаж, тэдгээрийн амсрыг доош унжуулан, тус бүрийн амсрыг алтан шармал могойн ам маягтай үйлдэж сүүлээр нь мөнгөн модыг ороолгон урлажээ. Эдгээр хоолойн нэгээс дарс, нөгөөгөөс дан айраг, гурав дахиад балын ундаа, дөрөв дэхээс будааны шар айраг гоождог байв. Модны ёроол хавьд амттан ундааг юүлэх тусгай мөнгөн савнуудыг хоолой бүрийн дор тосон байрлуулжээ. Мөнгөн модны орой дээр бүрээ барьсан Ангель хэмээх тэнгэрийн элчийн дүрийг Вильгельм дархан урлан босгож модны доорхи газарт хүн далд орохуйц зоорь бэлдэн модны голоор Ангелийг хүртэл бас нэг цорго үйлджээ. Модны мөчир, навч, жимс бүгдийг дан мөнгөөр урлажээ.

В. Монголын их хаад аливаа шашныг ялгаварлан үздэггүй шашин шүтэх эрх чөлөөг эрхэмлэн дээдэлдэг байсан. Хар хорум хотод дэлхийн 3 том шашин болох Будда, Христос, Лалын болон бөө мөргөлийн ёсны төлөөлөгчид тус тусын сүм хийдийг байгуулж, шашин номын үйл ажиллагаа явуулж байжээ. Г. Монголын эртний нийслэл Хархорум хотын туурь Монгол улсын Өвөрхангай аймгийн Хархорин сумын нутагт оршдог. Хархорум хотын туурийг 1948-1949 онд С.В.Кисилев, Х.Пэрлээ нарын, 1978-1985 онд Н.Сэр-Оджав, Д.Цэвээндорж, Д.Баяр нарын, 1995-1997 онд ЮНЕСКО-гийн ивээл дор Монгол, Японы судлаач эрдэмтэд, 2000 оноос Монгол, Германы эрдэмтэд судлан шинжилсэн. Судалгаа шинжилгээний ажил, археологийн малтлагын үр дүн, олдсон олдвор хэрэглэгдэхүүнүүд нь Хархорум хотын хөгжил, төлөвлөлт, барилга архитектурын хөгжлийн төвшин, цар хүрээ, онцлогийг тал бүрээс нь нээн харуулж, Хархорум нь тухайн үедээ өрнө, дорнын олон улс орныг холбосон Монголын эзэнт гүрний Нийслэл хот байсныг давхар нотлоод байна.

<https://mongoltoli.mn/history/h/685>

4. Үр дүнгийн танилцуулга

1. Дээр дурдсан эх сурвалж А болон Б-г харьцуулан шинжилж, дараах асуултуудад хариулна уу.

- Их монгол улсын үед хот суурин байсан уу? байсан бол ямар нэртэй байсан бэ? Нотолж болох баримт, эх сурвалж юу вэ?

- Мөнгөн модыг ямар зорилгоор, хэдийд, хаанахын, ямар уран бүтээлч, хэрхэн, яаж бүтээсэн бэ?

2. Эх сурвалж Б болон В-г харьцуулан шинжилж, дараах асуултад хариулна уу.

- Ангель хэмээх тэнгэрийн элчийн дүрийг яагаад дүрсэлсэн бэ? Мөнгөн модны утга бэлгэдэл юу вэ?

	<p>3. Эх сурвалж А,Б,В,Г-г харьцуулан шинжлээд дараах асуултад хариулна уу - Мөнгөн модыг бүтээсэн шалтгаан юу вэ? Бахархах зүйл, үнэ цэнэ нь юу вэ?</p> <p>4. Эх сурвалжууд дахь баримт, мэдээллийг харьцуулан шинжилсэн үр дүнгээ танилцуулна. Монгол улсын газрын зурагт Хар хорум хотыг заана.</p> <p>5. Энэ хичээлээр судалсан Монголын түүх, соёлын дурсгалын тухай сэдэв хэр зэрэг сонирхолтой байсан бэ? Дараах хүснэгт дэх маш их; их; дунд зэрэг;бага;маш бага; гэсэн хариултуудаас сонгон, холбогдох дугуйг будаж тэмдэглэнэ үү.</p>					
5. Сурагчийн хандлагыг үнэлэх	Хариулт	Маш их	Их	Дунд зэрэг	Бага зэрэг	Маш бага
	Монголын түүх, соёлын дурсгалын тухай сэдэв чамд хэр сонирхолтой байв?					
	Монголын түүх, соёлын биет (эдийн) дурсгал - Хар хорум дах Мөнгөн мод -Монголын түүх, соёлын биет бус (оюуны) дурсгал					
	Монголын түүх, соёлын дурсгал яагаад өвлөгддөг тухай					

Багшид нэмэлт зөвлөмж

- НШС арга барилын асуудал (таамаглал) дэвшүүлэх, шинжлэн судлах үйлээ төлөвлөх, мэдээлэл цуглуулах, боловсруулах, нягтлан нотлох, танилцуулах гэсэн цогц алхам буюу бүтцийг хичээлийн эхэнд, сурагчдад үйлийн баримжаа болгож, оновчтой аргаар, маш товч танилцуулж болно.
- Эсвэл, тухайн алхам бүрд сурагчдыг ажиллуулж, хичээлийн дүгнэлт хэсэгт сурагчдаар өөрсдөөр нь цогц алхмууд буюу бүтцийг гаргуулж болно.
- Тухайн шинжлэн судлах арга барилыг сурагч бүр эзэмшихэд цогц алхмуудыг нь нэгж хичээлээр тодорхой төлөвлөхөд анхаараарай.
- Шинжлэн судлах арга барилын асуудал (таамаглал), ялангуяа асуудал дэвшүүлэх алхмыг ээлжит хичээл бүрээр хэрэгжүүлэх бололцоотойг анхаарах хэрэгтэй.
- НШС арга барил эзэмших хичээлийг 80 минутаар төлөвлөн хэрэгжүүлж болохыг анхаарна уу.
- “Шинэ мэдлэг, санаа гарган авахад чиглэсэн, нийгмийн үзэгдэл, үйл явцын шалтгаан, шинж чанар, холбоо, харилцааны талаарх урьдчилсан төсөөллийг таамаглал” гэнэ. Таамаглал нь тухайн шинжлэн судлах арга барилын эхний алхам, бас хэрэгсэл гэдгийг сурагчдад цэгцлэн тодотгож өгөөрэй.

Эх сурвалж: БХ., (2019) .,“ЕБС-ийн сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн нөхцөл байдлын судалгаа”, УБ.

Боловсруулсан: Проф.О.Пүрэв (БХ,БХСС)